

БАТЛАВ
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ТӨМӨРДУЛАМ
2023 оны 08 дугаар сарын 15

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ
СТАНДАРТЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 08 дугаар сарын 15 -ны өдөр

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр:	Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны стандартын төсөл боловсруулах ажлын даалгавар
Ажил гүйцэтгэх хугацаа:	Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 90 хоног

ҮНДЭСЛЭЛ.

Хууль эрхзүйн үндэслэл

Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг боловсруулах ажил нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх бөгөөд дараах баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай УИХ-ын тогтоол “Алсын хараа 2050”
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5 дахь заалт “Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ”.
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 24.1 Нийслэлийн чиг үүрэг 24.1.15 “хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт” гэсэн чиг үүрэг тусгагдсан.
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль 21.1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 21.1.3 нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт заавар батлах, 32.2 Нийслэл хотын оршин суугч дараах үүрэгтэй: 32.2.3 нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх.
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль 101 дүгээр зүйл. Хотын стандарт. 101.1. Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно. 101.2. Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

ЗОРИЛГО.

Нийслэлийн нутаг дэвсгэрт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах замаар гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулах, айл өрх бүр эрүүл, тохилог орчинд амьдрах боломжийг бүрдүүлсэн байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй эко амины сууцны төлөвлөлт ашиглалт, суурилуулалтад тавигдах техникийн болон технологийн ерөнхий шаардлагыг тодорхойлох зорилготой.

АГУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА.

Судалгаанд дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

Д/д	Агуулгын нэр	Агуулгын хүрээнд шаардлагатай мэдээлэл
1	Зорилго	Эрчим хүчний хэмнэлттэй эко амины сууцны төлөвлөлт ашиглалт, суурилуулалтад тавигдах техникийн болон технологийн ерөнхий шаардлагыг тодорхойлох.
2	Хамрах хүрээ	Нийслэлийн нутаг дэвсгэрт эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг төлөвлөх, ашиглахад дагаж мөрдөх.
3	Нэр томъёоны тодорхойлолт	Судалгааг боловсруулахад ашигласан, шинээр ашиглагдсан нэр томъёоны тодорхойлолтуудыг тайлбарлан тусгасан байх.
4	Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төлөвлөлтийн ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none">• Эко, ногоон амины орон сууцны төлөвлөлтийн ерөнхий шаардлага• Архитектур төлөвлөлтийн ерөнхий шаардлагуудыг судалж тусгах
5	Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төрөл ангилал	Ногоон орон сууцны төрөл ангиллыг судлан төрөл ангил тус бүрд тавигдах шаардлагыг тусгасан байх.
6	Инженерийн шугам сүлжээ ба барилга, байгууламжид тавигдах шаардлага	Эрчим хүчний хэмнэлттэй амины сууцны <ul style="list-style-type: none">• Ус хангамж• Ариутгах татуурга• Дулаан хангамж• Цахилгаан хангамжид тавигдах ерөнхий шаардлагыг судалж тусгасан байх.
7	Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны материал, технологийн ерөнхий шаардлага	Барилгын материал нь хорт бодис, хүнд металлын агууламжгүй, барилга доторх хүмүүсийн эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, тухайн материалын үйлдвэрлэл нь байгальд ээлтэй, хүлэмжийн хий ялгарлыг нэмэгдүүлэхгүй барилгын материалын шаардлагуудыг судлан тусгах
8	Сэргээгдэх эрчим хүч-Нарны зайн системийн ашиглалт, угсралт, суурилуулалтын ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none">• Сэргээгдэх эрчим хүч тэр дундаа Нарны эрчим хүч ашиглаж цахилгаан ба дулаан шийдэх шийдэлийг судлан тусгах.• Нарны зайн системийн ашиглалт, суурилуулалт, угсралтад тавигдах ерөнхий шаардлагыг судлан тусгасан байх.

9	Эрчим хүний хэмнэлттэй барилгын гадна орчны ногоон байгууламжид тавигдах шаарлага	Барилга нь хүний эрүүл мэндээс гадна байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөгүй ногоон байгууламж, ногоон байгууламжийн төлөвлөлтийн ерөнхий шаардлагуудыг судлан боловсруулсан байх.
10	Шалгуур үзүүлэлт	Эрчим хүчний хэмнэлттэй амины сууцыг стандарт шаардлага хангаж байгаа эсэхийг хянасан шалгах хуудас боловсруулсан байх.
11	Ашигласан материалын жагсаалт	Судалгаанд эх сурвалж болгон ашигласан аливаа баримт, мэдээлэл, хууль, тогтоомж, стандарт, норм дүрэм болон холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журам, заавар, судалгаа, асуулгын хуудас зэрэг мэдээллийн эх үүсвэрийг хавсаргана.

ТУСГАЙ ШААРДЛАГА.

Хэл найруулгад тавигдах шаардлага:

- Хэл найруулга нь зөв оновчтой байх;
- Нэр томъёоны тайлбартай байх;
- Монгол хэлний зөв бичих дүрмийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Тайланг 4 хувь хийж, цаасан болон CD хуулж ирүүлэх;
- Хэвлэлийн эх бэлтгэлийг хийсэн байх /эх файлын хамгийн сүүлийн хувилбар дээр засвар хийх боломжтой байхаар хэвлэлийн эх бэлтгэлийг бэлтгэсэн байх “docx”/;
- Хэвлэл нь чанарын шаардлага хангасан буюу өндөр нягтралтай байна.

Баримт бичгийн зурагт тавигдах шаардлага, үзүүлэлтийг оруулах

- Гэрэл зураг нь анхны болон 2 дахь эх үүсвэрээс авсан, өндөр чанартай, гэрлийн бууралтгүй, фокус сайтай байна;
- Бусад эх үүсвэрээс авсан зургийг заавал тайлбар, эшлэл, товч мэдээллийн хамт ашиглана;
- Харагдах байдлын 3 хэмжээст /Render, 3d/ зургийн нягтрал /resolution/ нь 300 dpi, pixels inch -ээс багагүй, JPEG, JPG, PNG өргөтгөлтэй байна;
- Зургийн эх сурвалж /Autocad, 3DS MAX, Sketchup, Lumion/-ийн файл болон texture, material-ийг хавсарган файл хэлбэрээр хүлээлгэн өгөх.

ТАЙЛАГНАХ, ХҮЛЭЭН АВАХ

Зөвлөх баг нь эхлэлийн тайланг гэрээ байгуулснаас хойш 21 хоногийн дотор, дундын тайланг гэрээ байгуулснаас хойш 60 хоногийн дотор Захиалагчид Монгол хэл дээр ирүүлнэ. Тайланг .pdf, .docx, .xlsx, хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004 стандартын дагуу боловсруулсан байна.

Судалгааны тайлан нь зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэсэн ажил, түүний хүрээ, үе шатыг бүхэлд нь хамруулсан байна.

Захиалагч ажлын гүйцэтгэлийг хангалтгүй гэж үзвэл гүйцэтгэгчээс хэсэгчлэн болон бүхэлд нь сайжруулан боловсруулна.

Боловсруулсан баримт бичиг, ашигласан эх сурвалж, судалгааны эх бичвэрийн файл, дэлгэрүүлж унших материал, цахим хуудасны хаяг, бусад дагалдах материалын жагсаалтыг шаардлага хангасан байдлаар хавсаргана.

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ:

Судалгааны ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:

Д/д	Ажлын үе шат	Хугацаа 90 хоног	Тавигдах шаардлага
1	Суурь судалгаа хийх	14-21	Судалгааны хүрээнд хийгдэх ажлуудын мэдээллийг цуглуулж аргачлалыг боловсруулсан байна.
2	Дундын тайлан боловсруулах	45-60	1. Дундын тайлангийн эхний хувилбар боловсруулах; 2. Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004 стандартын дагуу боловсруулсан байна. 3. Сонирхогч талуудаас санал авах: 3. Саналыг тусган сайжруулан засварлах; 4. Дундын тайланг захиалагчид танилцуулж, санал, шүүмж авах;
3	Тайланг эцэслэн хүлээлгэн өгөх	75-90	Судалгааны тайланг эцэслэн хүлээлгэн өгөх; (Судалгааны тайланг файл (.docx, .pdf, .xlsx) болон, хэвлэмэл байдлаар 4 хувь бэлтгэн ирүүлнэ.)

ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан 3-аас доошгүй гишүүнтэй хуулийн этгээд байна. Үүнд:

- Зөвлөх нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд аж ахуйн нэгж байгууллага, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, шаардлага хангасан мэргэжилтнүүдээс бүрдсэн баг;
- Судалгаа, шижилгээ хийж байсан туршлагатай байх;
- Монгол, Англи хэлний бичгийн ур чадвартай байх;

Мэргэжил:

- Багийн ахлагч: Хот төлөвлөгч, Архитектур, Ландшафт архитектур, Барилгын инженер, Сэргээгдэх эрчим хүчний инженер мэргэжилтэй байх.
- Багийн гишүүд: Хот төлөвлөгч, Судлаач, Архитектур, Ландшафт архитектур, Дизайнер, Судлаач, Газар зохион байгуулагч, Сэргээгдэх эрчим хүчний инженер мэргэжилтэй байх.

Туршлага:

- Багийн ахлагч: Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан байх.
- Багийн гишүүд: Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх.

- Судалгаа шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцож байсан ажлын туршлагатай байх;
- Судалгаа, шинжилгээний материалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт хийх чадвартай байх
- Аливаа бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах арга зүй, ур чадвар, дадлага, туршлагатай байх.
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын туршлагыг судлах зохих шатны мэдлэгтэй байх;

Хууль, бодлогын баримт бичиг, стандартын төсөл боловсруулах, бодлогын судалгаа, дүн шинжилгээний ажил өмнө хийж, гүйцэтгэж байсан бол давуу тал болно.

ОНЦГОЙ НӨХЦӨЛ

Хотын стандартын төслийг боловсруулахад дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

1. Шинэ гарсан технологи, орчин үеийн шаардлага, эрх зүйн баримт бичиг, бусад холбогдох стандарт, норм дүрэм, аюулгүй техник, ажиллагаа, эрүүл ахуйн норматив баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан байна.
2. Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004 стандартын дагуу боловсруулсан байна.
3. Зөвлөмжийн дагуу шаардлагатай өөрчлөлт, боловсруулалт, сайжруулалт хийнэ.
4. Төслийн хүрээнд боловсруулагдсан, худалдан авч ашигласан бүх цахим болон хэвлэмэл материал, зураг зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх.
5. Хотын стандарт төслийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, тайлан, баримт бичиг нь Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу Хотын стандарт, хяналтын газрын өмч болно.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА:



Э.ДАВААХАТАН

БОЛОВСРУУЛСАН:
ХОТЫН ХӨГЖЛИЙН СТАНДАРТЫН
МЭРГЭЖИЛТЭН



М.АМАРЗАЯА